

Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.04.11

Олон улсын  
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Онцлох индексүүдийн өөрчлөлт


Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

Америкийн индекс	Одоогийн ханш	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$34,721.12	\$34,670.88	0.14%	\$33,169.25	4.68%	\$33,800.60	2.72%
S&P 500	\$4,488.28	\$4,547.56	-1.30%	\$4,271.06	5.09%	\$4,127.99	8.73%
Nasdaq	\$13,711.00	\$14,374.47	-4.62%	\$13,095.00	4.70%	\$13,900.00	-1.36%

Европийн индекс	Одоогийн ханш	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 14,283.67	€ 14,283.67	0.00%	€ 13,332.27	7.14%	€ 15,202.68	-6.05%
FTSE 100	£7,669.56	£7,538.90	1.73%	£6,966.81	10.09%	£6,942.20	10.48%

Азийн индекс	Одоогийн ханш	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,230.77	¥4,226.69	0.10%	¥4,281.67	-1.19%	¥5,112.21	-17.24%
Hang Seng	HKD 21,872.01	HKD 21,606.30	1.23%	HKD 20,838.58	4.96%	HKD 29,008.70	-24.60%
Nikkei 225	JPY 26,985.80	JPY 27,685.50	-2.53%	JPY 24,956.61	8.13%	JPY 29,708.98	-9.17%

Индексийн өөрчлөлт



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## **Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ**

### **Ellon Musk Twitter Blue үйлчилгээний төлбөрийг Dodgecoin-оор төлөх сонголтыг нэмэх зэрэг санааг дэвшүүллээ**

Tesla болон SpaceX-ийн гүйцэтгэх захирал Ellon Musk саяхан Twitter компанийн 9.2 хувь хүрэх хувьцааг худалдаж авснаар тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (ТУЗ) гишүүн болсон. Ингэснээр шийдвэр гаргахад нөлөөлөхүйц эрх мэдэлтэй болсон тул Twitter Blue-г шинэчлэх хэд хэдэн санал дэвшүүлэв.

Twitter Blue нь төлбөр төлж бүртгүүлсэн хүмүүст зориулсан жиргээг буцаах, Twitter нүүр зургийн дизайныг солих гэх мэт нэмэлт функц бүхий үйлчилгээг санал болгодог бөгөөд зөвхөн АНУ, Канад, Австрали, Шинэ Зеландад ашиглаж байгаа юм.

Ням гарагт Ellon Musk Twitter Blue дээр нэмэлтээр төлбөрийн үнийг буулгах, Dodgecoin-оор төлбөрөө төлөх сонголтыг олгох, зар сурталчилгаа гаргахгүй байх зэрэг саналыг дэвшүүлэв. Мөн Twitter Blue-д бүртгүүлсэн хүн бүр баталгаажуулалтын тэмдэг авах нь зүйтэй хэмээн твиттер хуудсандаа бичжээ.

Twitter Blue-д бүртгүүлэхэд сарын 3 ам.доллар төлдөг бол Ellon Musk-ийн саналаар сарын 2 ам.доллар болгож, 12 сарын төлбөрийг урьдчилан авах, 60 хоногийн дотор баталгаажуулалтын тэмдэг авах боломжтой болох, хэрэв хууль бусаар ашигласан тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүйгээр тус үйлчилгээнээс хасагдах зэрэг орж байна.

### **ОХУ Украины дайны улмаас Азийн зарим оронд хүнс тэргүүтэй бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байна**

“Economic Intelligence Unit”-ээс гаргасан судалгаагаар Ази, Номхон далайн зарим орнууд ОХУ Украины мөргөлдөөний улмаас эдийн засгийн хувьд багагүй хохирол амсахаар байна.

ОХУ болон Украин нь түүхий эд үйлдвэрлэдэг гол орнууд тул тус орнуудаас худалдан авалт хийдэг Ази-Номхон далайн орнууд үнийн өсөлт, ялангуяа хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс болгоомжилж байна.

Азийн зарим оронд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үр тарианы хомсдол үүсэж хэдийн үнэ нь өсөж эхэлжээ.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Тухайлбал, Зүүн өмнөд Азийн улс орнууд ОХУ-аас бордоо, үр тарианы хувьд хамааралтай байдаг нь хөдөө аж ахуйн салбарт шууд нөлөө үзүүлэх болно.

Зүүн хойд Азийн хувьд дэлхийн чип үйлдвэрлэгчдийн өлгий нутаг тул хагас дамжуулагчийн үйлдвэрлэлд ашигладаг ховор хийг ОХУ-аас худалдан авдаг. Энэ нь Орос-Украины дайнаас болж импортын тал дээр нөлөө үзүүлэх магадлалтай.

Мөн зарим Ази-Номхон далайн орнууд ОХУ-аас үргэлжлүүлэн зэвсэг худалдан авах боломжгүй болно.

**Түүхий эдийн үнийн өсөлтөөс ашиг хүртэх улс орнууд:**

- Нүүрс экспортлогчид: Австрали, Индонези, Монгол
- Түүхий нефть экспортлогчид: Малайз, Бруней
- Шингэрүүлсэн байгалийн хий: Австрали, Малайз, Папуа Шинэ Гвиней
- Никель нийлүүлэгчид: Индонез, Шинэ Каледони
- Улаан буудай нийлүүлэгчид: Австрали, Энэтхэг

**Үнийн өсөлтөд хамгийн өртөмтгий улсууд**

**(2020 онд Орос/Украинаас импорт хийсэн хувиар):**

- Бордоо: Индонез (15% -иас дээш), Вьетнам (10% -иас дээш), Тайланд (10% -иас дээш), Малайз (ойролцоогоор 10%), Энэтхэг (6% -иас дээш), Бангладеш (бараг 5%), Мьянмар (3% орчим, Шри Ланка (ойролцоогоор 2%))
- ОХУ-ын үр тариа: Пакистан (40% орчим), Шри Ланка (30% гаруй), Бангладеш (20% гаруй), Вьетнам (бараг 10%), Тайланд (ойролцоогоор 5%), Филиппин (ойролцоогоор 5%), Индонез (5%-иас бага), Мьянмар (5%-иас бага), Малайз (5%-иас бага)
- Украины үр тариа: Пакистан (ойролцоогоор 40%), Индонез (20 гаруй%), Бангладеш (бараг 20%), Тайланд (10 гаруй%), Мьянмар (10 гаруй%), Шри Ланка (бараг 10%), Вьетнам (5% -иас бага), Филиппин (ойролцоогоор 5%), Малайз (ойролцоогоор 5%)

**2000-2020 онд ОХУ-ын зэвсгийн импортоос хамгийн их хамааралтай улс орнуудыг нийт импортод эзлэх хувь хэмжээгээр нь жагсаав.**






























- Монгол (100 орчим%), Вьетнам (80 гаруй%), Хятад (80 гаруй%), Энэтхэг (60 гаруй%), Лаос (40 гаруй%), Мьянмар (40 гаруй%), Малайз (20 гаруй%), Индонез (10%-иас дээш), Бангладеш (10%-иас дээш), Балба (10%-иас дээш), Пакистан (10%-иас бага)

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases for the week beginning April 04, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
									
									
									
									
									
									
									
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2022 Earnings Whispers	

### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases for the week beginning April 11, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
									
									
									
									
									
									
									
									
									
									
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2022 Earnings Whispers	

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.